2.8. Салбар зөвлөл нь 7-гоос доошгүй гишүүнтэй байна.

2.9. Салбар зөвлөлийн зардлыг аймгийн Засаг дарга хариуцах бөгөөд тухайн жилийн төсөвтөө тусгаж санхүүжүүлнэ.

2.10. Салбар зөвлөл нь аймгийн Засаг даргын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

Гурав. Салбар зөвлөлийн ажиллах журам

3.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь зөвлөлийн хурал байна.

3.2. Салбар зөвлөлийн хурлыг хагас жил тутамд хийж, ээлжит бус хурлыг Салбар зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

3.3. Салбар зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд Салбар зөвлөлийн гишүүн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга даргална.

3.4. Салбар зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцүүлэх байгууллага холбогдох материалаа зөвлөлийн нарийн бичигт хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлнэ. Хурлын материалыг хурал болохоос 5 хоногийн өмнө гишүүдэд тараана.

3.5. Салбар зөвлөлийн хурлыг гишүүдийн олонх ирсэн тохиолдолд хуралдуулж, хурлын тэмдэглэлийг нарийн бичиг хөтөлж, хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.6. Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, хурлаас аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, албан бичиг болон холбогдох байгууллагын шийдвэр, дүгнэлт, зөвлөмж гаргана.

3.7. Шаардлагатай тохиолдолд салбар зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан эрдэмтэн, мэргэжилтэн, хүмүүсийг оролцуулж болно.

Дөрөв. Салбар зөвлөлийн эрх, үүрэг

4.1. Салбар зөвлөл дараах үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бодлого тодорхойлох, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал гаргах;

4.1.2. Монгол Улсын нэгдэн орсон химийн бодисын талаарх олон улсын гэрээ болон үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тухайн салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлтэд хяналт тавих;

4.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн зөрчил, маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн зөвлөмж, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлд мэдэгдэх.

4.1.4. Химийн хорт болон аюултай бодистой холбогдож үүссэн аюул, осол, онцгой байдал зарласан тохиолдолд хор аюулыг бууруулахад мэргэжил арга зүйгээр хангаж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

4.1.5. Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, устгахад аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

4.1.6. Химийн хорт болон аюултай бодистой холбогдсон хууль,тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, стандартыг мөрдүүлэх, хяналт тавих;

4.1.7. Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагсдын мэдлэг, чадвар, иргэдийн химийн хорт болон аюултай бодисын талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт, суртчилгаа зохион байгуулах;

4.1.8. Бусад;

4.2. Салбар зөвлөл дараах эрхтэй байна:

4.2.1. Химийн хорт болон аюултай бодисын асуудлаар зөвлөмж, дүгнэлт гаргах, хяналт тавих ажлын хэсэгт холбогдох байгууллага, мэргэжилтэн, шинжээч, улсын байцаагч нарыг татан оролцуулах;

4.2.2. Химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр аливаа байгууллагаас гаргасан шийдвэр, үйл ажиллагаань хууль тогтоомж, химийн хорт болон аюултай бодисын аюулгүй байдлыг хангах бодлогод нийцэхгүй байна гэж үзвэл хүчингүй болгох, зогсоох санал, дүгнэлтээ зохих байгууллагад гаргах;

4.2.3. Химийн хорт болон аюултай бодистой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас шаардлагатай мэдээлэл, тайлан, судалгаа, баримт материалыг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах.

4.2.4. Химийн хорт болон аюултай бодисын ашиглалтад шалгалт, тооллого хийх, ажлын зураг авах, шинжилгээнд сорьц, дээж авах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад чөлөөтэй нэвтрэх;

4.2.5. Санал, дүгнэлт гаргахад шаардлагатай лабораторийн шинжилгээг дотоод, гадаадын лабораторид хийлгэх.

4.2.6. Холбогдох хууль тогтоомжинд заасан бусад эрхийг эдлэнэ.

__oOo__

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/98 Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-ийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хамгаалалтыг сайжруулах зорилгоор "Ногоон Алтай" дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: В.Рэнцэндорж -Засаг даргын орлогч

Гишүүд: П.Баасан -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Мянганбуу -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Б.Эрдэнэбаяр -Сум дундын ойн ангийн дарга

С.Энхцолмон -Хот тохижилт үйлчилгээний газрын дарга

Д.Наянбуу -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Батмөнх -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Буянтөгс -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

Б.Пүрэвдорж -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой, ургамлын асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Батмагнай -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

2. "Ногоон Алтай" дэд хөтөлбөрийг 2017 оны нэгдүгээр улиралд багтаан боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулах бэлтгэл ажлыг хангахыг ажлын хэсэг /В.Рэнцэндорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00334

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/99 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын дулааны эрчим хүчний чанар, хүртээмжийг сайжруулах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай хамтран ажиллах санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, "Мандал голомт" ХХК-д Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрчим хүчний зохицуулах хорооноос өгсөн албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

2. Дулааны үйлдвэрлэл эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай хамтран ажиллах саналыг боловсруулан 2017 оны 05 дугаар сарын 01-ний дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг санал боловсруулах ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Албан шаардлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг төлөвлөгөөнд заасан хугацаанд тухай бүр Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00351

Аймгийн Засаг даргын 20.7 оны
04 сарын 03-ны өдрийн А/99 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

САНАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга: -аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга

Гишүүд: -аймгийн Ерөнхий архитектор
-аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
-Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд Алтай хотын захирагч
-аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах Мэргэжилтэн
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын орон сууц, нийтийн аж ахуй хариуцсан мэргэжилтэн
-аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн
-Есөнбулаг сумын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн
-“Мандал Голомт” ХХК-ий ерөнхий инженер
-“Мандал Голомт” ХХК-ий зөвлөх инженер
-“Ундрам-Оюу” ХХК-ий захирал
-“Удмын Ундраа” ХХК-ий захирал

Нарийн бичгийн дарга: -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Мэргэжилтэн
-аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

__oOo__

Аймгийн Засаг даргын 20.7 оны
04 сарын 03-ны өдрийн А/99 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

САНАЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга: -аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга

Гишүүд: -аймгийн Ерөнхий архитектор
-аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
-Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд Алтай хотын захирагч
-аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах Мэргэжилтэн
-аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын орон сууц, нийтийн аж ахуй хариуцсан мэргэжилтэн
-аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн
-Есөнбулаг сумын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн
-“Мандал Голомт” ХХК-ий ерөнхий инженер
-“Мандал Голомт” ХХК-ий зөвлөх инженер
-“Ундрам-Оюу” ХХК-ий захирал
-“Удмын Ундраа” ХХК-ий захирал

Нарийн бичгийн дарга: -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Мэргэжилтэн
-аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

__oOo__

Аймгийн Засаг даргын 2017 оны
04 сарын 03-ны өдрийн А/99 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга: -аймгийн Засаг даргын орлогч, Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга

Гишүүд: -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

-аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

-Есөнбулаг сумын Засаг дарга, Алтай хотын захирагч

-Есөнбулаг сумын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын орон сууц нийтийн аж ахуй хариуцсан дарга

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын орон сууц нийтийн аж ахуй хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: -аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

__oOo__

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/100 Алтай хот

Мал амьтны шилжилт, хөдөлгөөнийг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.3-ын "А" заалт, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, 4.5.7, 4.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Олон улсын худалдааны хорио цээрт малын гоц халдварт шүлхий, цэцэг, мялзан өвчин Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Говьсүмбэр, Дархан, Булган, Архангай, Ховд, Баян-Өлгий зэрэг аймгуудад голомтлон гарч байгаатай холбогдуулан нийт аймгуудаас мал, амьтан худалдан авах, шилжилт хөдөлгөөн хийхийг 2017 оны 04 дүгээр 03-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, малчид, мал бүхий иргэдэд сэрэмжлүүлэг хүргэж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Баян-Эрдэнэ/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/, Цагдаагийн газар /Г.Түмэннасан/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00353

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/101 Алтай хот

Мал эрүүлжүүлэх ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.3-ын "А" заалт, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 4.5.4, 4.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ариутгал, хардваргүйтгэл хийх ажлыг 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны хооронд зохион байгуулсугай.

2. Мал, амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудыг татан оролцуулж, ажиллах хүн, хашаа, хороо, тээврийн хэрэгслээр ханган, тогтоосон хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах биобэлдмэл, вакцин, эм урвалжийг хугацаанд нь татан авч, хуваарилан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б. Баян-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

4. Тус арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т даалгасугай.

5. Ажлын явц үр дүнг Засаг даргад тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Баян-Эрдэнэ/-т дааалгасугай

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00343

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/61 Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3-д, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотод 2017 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдах хаврын бүсийн хурдан морины уралдаанд 10000000 /Арван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

3. Төсөв санхүүгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт, аудитын алба /Д.Ганзориг/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00239

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/62 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 93 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн Цагдаагийн газарт автомашин нийлүүлэх ГАА.ОНӨГ/201700005 дугаартай ажлыг "Монобилка" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга /Ч.Бат-Эрдэнэ/-д олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00230

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/63 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 94 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин нийлүүлэх ГАА.ОНӨГ/201700004 дугаартай ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар /Ч.Бат-Эрдэнэ/-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00228

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/64 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 91 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Төгрөг, Хөхморьт сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин нийлүүлэх ГАА.ОНӨГ/201700003 дугаартай ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар /Ч.Бат-Эрдэнэ/-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00226

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/65 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн дулаан хангамжийн шугам сүлжээнд горим тохируулга, тооцоо судалгаа хийх "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ий орон нутгийн дулаан хангамжийн хэсгийн инженерүүдтэй хамтран ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Уган-Эрдэнэ -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: П.Бат-Очир -Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

А.Норов -Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч

М.Туул -Есөнбулаг сумын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

Б.Лхагва-Очир -аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

Б.Баасан -"Удмын Ундраа" ХХК-ий захирал

Б.Хишигдорж -"Мандал Голомт" ХХК-ий ерөнхий инженер

Д.Батбилиг -"Ундрам-Оюу" ХХК-ий ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Дулаан хангамжийн шугам сүлжээнд горим тохируулга, тооцоо судалгаа хийх инженерүүдийг шаардлагатай мэдээллээр хангаж, хамтран ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /М.Уган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00224

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/66 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Багийн үйлчилгээний цогц төвийн шинэ барилга /"Марал-Алтай" өрхийн эрүүл мэндийн төвтэй/, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн спорт заалны өргөтгөл барих ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ч.Бат-Эрдэнэ -Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: С.Пагамдулам -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Цэцэгмаа -"Ногоон алт" ТББ-ын ажилтан

Г.Энхбаяр -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ч.Бат-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00245

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/67. Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан, Есөнбулаг сумын орон нутгийн хөгжлийн сан, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардал зэрэг эх үүсвэрүүдээс санхүүжигдэх Есөнбулаг сумын Баянхайрхан багт хөв байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ч.Бат-Эрдэнэ -Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Б.Содмаа -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

П.Долгорсүрэн -"Ногоон алт" ТББ-ын ажилтан

Г.Энхбаяр -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ч.Бат-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 000248

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/68 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Баян-Уул сумын Сум дундын эмнэлгийн шүдний эмчилгээний багаж тоног төхөөрөмж нийлүүлэх, Төгрөг сумын ундны ус зөөвөрлөх авто машин нийлүүлэх ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: П.Баасан -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Д.Энхжаргал -Эрүүл мэндийн газрын эмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Ч.Цэцэгмаа -"Ногоон Алт" ТББ-ын ажилтэн

Б.Мөнх-Эрдэнэ -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /П.Баасан/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00250

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/69 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Улсын чанартай авто замын дагуух Алтай хот доторх аюулгүйн тойргийн орчинг тохижуулах, "Хоггүй цэвэр-Алтай" хөтөлбөрийн хүрээнд Алтай хотын гудамж талбай, гэр хорооллын хог зайлуулах, хогийн пункер байгуулах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: П.Баасан -Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: С.Пагамдулам -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Алтайбаяр -"Ногоон алт" ТББ-ын ажилтан

Б.Болормаа -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /П.Баасан/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00252

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/70 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтай хотын гэр хорооллын хатуу хучилттай авто замын засвар, арчлалт хийх, Цээл сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12 жилийн сургуулийн гал тогооны барилгын засвар ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ч.Жаргалсайхан -Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Э.Золзаяа -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ч.Цэцэгмаа -"Ногоон алт" ТББ-ын ажилтан

Ж.Бат-Эрдэнэ– Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Жаргалсайхан/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00254

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/71 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр эмнэлгийн нэгдсэн хог хаягдлын барилгын дулаан, цэвэр ус, ариутгах татуургын шугам татах, 5, 6, 7, 20 дугаар байр чиглэлийн ариутгах татуургын төв шугам сүлжээг шинэчлэн солих ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ч.Жаргалсайхан -Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: С.Пагамдулам -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

П.Долгорсүрэн -"Ногоон алт" ТББ-ын ажилтан

Г.Энхбаяр -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ч.Жаргалсайхан/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00256

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/72 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, уст цэгийн хайгуул хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: П.Баасан -Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Содмаа -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
П.Долгорсүрэн -"Ногоон алт" ТББ-ын ажилтан
Г.Энхбаяр -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /П.Баасан/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00258

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/73 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтай хотын "Сайн байна уу" хаалга шинээр хийх, Шүтээний өндөрлөг цогцолборыг их засварт оруулах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: -Ч.Бат-Эрдэнэ -Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Э.Бямбаа -Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Ч.Цэцэгмаа -"Ногоон алт" ТББ-ын ажилтан

Б.Мөнх-Эрдэнэ -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ч.Бат-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00260

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/74 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр "Ногоон-Алтай" хөтөлбөрийн хүрээнд "Ногоон ажлын байр" төслийг хэрэгжүүлж Алтай хотын хаалганаас Баарангийн даваа хүртэл 10 км автозамын дагуу 12000 ширхэг мод тарих байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Алтайбаатар -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Содмаа -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
П.Долгорсүрэн -"Ногоон алт" ТББ-ын ажилтан
Т.Баттөмөр -Есөнбулаг сумын иргэн

Нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Б.Алтайбаатар/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

02 00261

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/75 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаврын бүсийн хурдан морины уралдаанд оролцох унаач хүүхдүүдийг бүртгэх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Болормаа -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Г.Ариунболд -Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Сономцэвээн -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргаа хамтын ажиллагааны албаны дарга
Б.Төгсжаргал -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрх, хамгаллын мэргэжилтэн
Д.Болормаа -Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч, цагдаагийн хошууч
Ж.Билэгсайхан -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
Д.Баасанжаргал -Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
Л.Гантөмөр -Нэгдсэн эмнэлгийн гэмтэл, мэс заслын их эмч
М.Болдбаатар -"Дэлхийн зөн" ОУБ-ын Говь-Алтай Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн зохицуулагч

Нарийн бичгийн дарга: М.Ариунсанаа -Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүнд нөхцөл дэх хүүхэд хамгаллын мэргэжилтэн

2. Унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах талаар заавар зөвлөгөө өгч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /С.Болормаа/-д үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00266

Аймгийн Засаг даргын 20.17. оны 03.. дугаар
сарын 10..ны өдрийн А/76 дугаар
захирамжийн хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Овог нэр	Ам бүл	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Гэр бүлийн хамтын хэрэгцээнд өмчилж авсан захирамж				Өмчлөх эрх шилжүүлэн авагчийн овог нэр	Тайлбар
					Огноо	Дугаар	Хавсралт анд орсон дугаар	Өмчлөх эрх шилжүүлэгчийн овог нэр		
1	Чулуунбат Нисгэгч	4	Харзат баг 2-16 тоот	851.0	2007	184	65	Д.Дулам, Н.Азмаа, Н.Аз-Од,	Чулуунбат Нисгэгч	Засаг даргын захирамжаас шилжиж байгаа
2	Лхагваа Эрдэнэжаргал	5	Баяншанд баг 12-19 тоот	677.0	2007	06	48	Б.Мөнхцэцэг, Э.Нямбаяр, Э.Нямтайван	Лхагваа Эрдэнэжаргал	Засаг даргын захирамжаас шилжиж байгаа

__oOo__

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 10 өдөр Дугаар А/76 Алтай хот

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын захирамжаар гэр бүлийн хэрэгцээнд дундаа газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан хавсралтад дурдсан 2 иргэнд үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга /Ш.Дагва/, Улсын бүртгэлийн хэлтэс /Г.Чүлтэмжамц/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр захирамжийн хавсралтын 65, 2007 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар захирамжийн хавсралтын 48 дугаарт бүртгэгдсэн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Газар өмчлөх эрх нь сэргээгдсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00270

Аймгийн Засаг даргын 20..17 оны
03 сарын 17.-ны өдрийн А/177 дугаар
захирамжийн хавсралт

ДЮА0042

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
Нэг. Эмэгтэйчүүдийн зөвлөгөөн				
1	Бичиг хэргийн зардал	250	4500	1125000
2	Урилга	250	500	125000
3	Илгээлт	1ш	25000	25000
Дүн				1275.000
Хоёр. “Буянтай ээж” шалгаруулах ёслолын арга хэмжээ				
5	Өргөмжлөл, дурсгалын зүйл	8	25000	225000
	Дүн			225000
	НИЙТ ДҮН			1500.000

__oOo__

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 13 өдөр Дугаар А/77 Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.4 дэх заалт, Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.16 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулах арга хэмжээний зардалд 1500000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 1500000 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

3. Санхүүгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00276

Аймгийн Засаг даргын 2017 оны
03 сарын 13-ны өдрийн 4/78 дугаар
захирамжийн хавсралт

ДЮА0042

“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: -аймгийн Засаг даргын орлогч

Орлогч: -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга -Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд: -Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

-Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

-Хүнс хөдөө аж, ахуйн газрын дарга

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

-Биеийн тамир, спортын газрын дарга

-“Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын аймаг дахь Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн менежер /зөвшилцсөнөөр/

__oOo__

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 13 өдөр Дугаар А/78 Алтай хот

"Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил"
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/61 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эрүүл мэндийн салбарт 2017 оныг "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласугай.

2. "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил"-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Жилийн ажлын хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /В.Рэнцэндорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С. ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 00274